



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 01/115

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын
үзлэгийг зохион явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А\315 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хаврын хуурайшилтын улирал эхэлж ой хээрийн түймэр гарах эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан сумдын ой хээрийн түймэртэй тэмцэх томилгоот бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангуулах зорилгоор "Аймгийн Засаг даргын нэрэмжит" гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 3 дугаар сарын 26-31-ний өдрүүдэд сумдад зохион байгуулсугай.

2. "Аймгийн Засаг даргын нэрэмжит" гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг хийх, "Аврагч" тэмцээн зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, бэлэн байдлын үзлэг явуулах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, "Аврагч" тэмцээний удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах удирдамжид заагдсан чиглэлээр бэлтгэлийг хангаж үзлэгт хамрагдахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатарт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Бэлэн байдлын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

№	Нэр	Албан тушаал
1-р ажлын хэсэг		
1	О.Баярмагнай	Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахлах дэслэгч
2	Б.Нямхатан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга
3	Э.Батсайхан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны Ой, ургамлын ашиглалт хамгаалалт, түймрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
2-р ажлын хэсэг		
1	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч дэслэгч
2	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын уул уурхай тусгай хамгаалалттай газар хариуцсан мэргэжилтэн
3	Б.Гүрсүрэн	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны Ойжуулалт, байгалийн гамшиг, цөлжилт, бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. "Аврагч" тэмцээн зохион байгуулах, шүүх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

№	Нэр	Албан тушаал
1-р ажлын хэсэг		
1	Ч.Гантогтох	Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын дарга ахмад
2	Ц.Төмөрбаатар	Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын бүлгийн даргын үүрэг гүйцэтгэгч ахлах ахлагч
3	Э.Ууган-Эрдэнэ	Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 32 дугаар ангийн аврагч-гал сөнөөгч ахлах ахлагч
4	Г.Баттулга	Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 32 дугаар ангийн аврагч -гал сөнөөгч ахлах ахлагч
5	З.Бурмаа	Онцгой байдлын газрын Эмнэлгийн зааварлагч дэд ахлагч
2-р ажлын хэсэг		
1	Д.Тунгалагтуул	Онцгой байдлын газрын ангиллын сургалт сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн ахлах дэслэгч
2	С.Мөнхсүх	Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын бүлгийн даргын үүрэг гүйцэтгэгч ахлах ахлагч
3	Э.Болд-Эрдэнэ	Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 32 дугаар ангийн аврагч-гал сөнөөгч ахлах ахлагч
4	Т.Төгсжаргал	Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 32 дугаар ангийн аврагч-гал сөнөөгч ахлах ахлагч
5	А.Нандинцэцэг	Онцгой байдлын газрын Эмнэлгийн зааварлагч дэд ахлагч

**ХЭНТИЙ АЙМГИЙН “ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ”
ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГИЙН УДИРДАМЖ**

Зорилго: Хаврын хуурайшилт эхэлж ой хээрийн түймэр гарах эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан нийт сум, тосгоны түймэртэй тэмцэх томилгоот бүрэлдэхүүн, түймэр унтраахад ашиглах техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, үнэлгээ өгөх, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа хийхэд оршино.

Нэг. Ажлын чиглэл

1. Сумын ой хээрийн түймэр унтраах 1,2,3-р ээлжийн томилгоот бүрэлдэхүүний томилгоо, тэдгээрийн хувийн бэлтгэл, үүргэвчний бүрдэлд үзлэг хийж үнэлгээ өгөх
2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, түймэр унтраах багаж, техник хэрэгслийн бүрдүүлэлт, засвар үйлчилгээ, бэлэн байдлыг шалгах
/Засгийн газрын 2013 оны 106-р тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75-р тушаалын дагуу суманд, иргэнд, мэргэжлийн ангид байвал зохих багаж хэрэгслийг бэлтгэх /
3. Хэнтий аймгийн Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудын дунд “Аврагч-2019” бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулна. /3-р хавсралтаар удирдамж, зааврыг хавсаргав/
4. Гамшгаас хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоол, түймрийн хохирлын акт тогтоох аргачлал, газрын суурь үнэлгээ өөрчлөгдсөн талаар мэдээлэл хийх
5. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, сумын Засаг дарга нартай хамтран ажиллах гурван талт гэрээ байгуулах

Үзлэгийн үеэр дараах бичиг баримтыг бэлэн байлгана.

1. Аймгийн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зөвлөл” -ийн 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болзолт уралдаан зарлаж хөрөнгө зарцуулах тухай” А\14 дугаар захирамж, дүгнэх журмын хүрээнд хийгдэж байгаа ажлын явцын танилцуулга
2. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ойн болон байгаль хамгаалах нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа байдал, гаргасан төлөвлөгөө, түүний хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний илтгэх хуудас
3. Түймэр унтраах дайчилгааны төлөвлөгөө /эх хувиараа/, түймэр унтраах 1,2,3-ээлжийн томилгоот бүрэлдэхүүн, машин техникийн томилгооны хуулбар
4. Түймрийн эрсдэлтэй газар нутаг болон малчин айл өрхийн судалгааг шинэчилж хүснэгт болон зурган /shp.file/ хэлбэрээр бэлтгэх
5. Сумын мэргэжлийн анги, байгууллага, ААН, ойн мэргэжлийн байгууллага, ойн болон байгаль хамгаалах нөхөрлөлүүд, баг. айл өрхүүдийн түймэр унтраах багаж хэрэгслийн дэлгэрэнгүй судалгааг хүснэгтээр бэлтгэх

6. Сумын айл өрх, нөхөрлөлүүдийн түймрийн эргүүлийн хуваарь, гүйцэтгэлийн мэдээллийг тус тус бэлтгэсэн байна.

**Хоёр: Бэлэн байдлын үзлэг явуулах хугацаа, бүрэлдэхүүн,
зохион байгуулалтын хэлбэр**

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газраас хамтарсан 10 хүний бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсэг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 03 дугаар сарын 31 -ны хугацаанд зохион байгуулна.

Гурав: Зохион байгуулалтын талаар

Газарзүйн байрлалыг харгалзан ойр байрлах сумдыг газар нутгийн хилийн заагт цуглуулан бусад сумдтайгаа туршлага солилцох боломжтойгоор үзлэгийг хээрийн байдлаар зохион байгуулна. /Зохион байгуулах газрыг хүснэгт болон зургаар оруулав/. Шатахууны зардлыг сум, тосгонууд өөрсдөө хариуцна.

Үзлэгт томилгоот бүрэлдэхүүн, машин техник, багаж хэрэгслийг хамруулах бөгөөд сумын Засаг дарга өөрийн биеэр удирдан зохион байгуулж бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг ханган оролцоно.

Ажлын хэсэг нь үзлэгийн дүнг бие бүрэлдэхүүнд танилцуулж, сумдын Засаг даргаар баталгаажуулах ба үзлэгийн үр дүнгийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллана.

Дөрөв. Дүнгийн талаар

Аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн дүнг Засаг даргын зөвлөлд 2019 оны 4 дүгээр сарын 10-ны дотор танилцуулж үр дүнг тооцно.

Үзлэгийн дүнг "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болзолт уралдаан"- ы нэгдсэн дүнд оруулж тооцно.

**СУМДАД БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ
ХИЙХ АЖЛЫН ХУВААРЬ**

д/д	Сумдын нэрс	Ажиллах хугацаа	Үзлэг зохион байгуулах газар
1-р баг			
1	Батширээт	03- р сарын 26, 27	Биндэрийн овоо Солбилцол: N 48° 22' 11,14" E 110° 15' 22,52"
2	Өмнөдэлгэр		
3	Биндэр		
4	Хурх		
5	Дадал	03- р сарын 28, 29	Шивэр мандал Солбилцол: N 48° 45' 33,79" E 111° 36' 15,73"
6	Баян-Адрага		
7	Норовлин		
8	Баян-Овоо	03- р сарын 30, 31	Баян уул Солбилцол: N 47° 49' 51,66" E 111° 28' 54,61"
9	Батноров		
10	Бэрх		
2-р баг			
1	Хэрлэн	03- р сарын 26, 27	Өндөрхаан уул Солбилцол: N 47° 27' 03,64" E 110° 30' 06,26"
2	Мөрөн		
3	Баянхутаг		
4	Өлзийт		
5	Тахилгат		
6	Цэнхэрмандал	03- р сарын 28, 29	Шивэрийн сайр Солбилцол: N 47° 33' 14,92" E 109° 10' 53,13"
7	Жаргалтхаан		
8	Дэлгэрхаан		
9	Хэрлэнбаян-Улаан		
10	Дархан	03- р сарын 30, 31	Салхитын урд /3 сумын зааг/ Солбилцол: N 46° 37' 48,19" E 110° 01' 02,70"
11	Бор-Өндөр		
12	Галшар		
13	Баянмөнх		

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН
АНГИУДЫН ДУНД ЗОХИОН ЯВУУЛАХ "АВРАГЧ-2019" БҮСИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Зорилго: Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бие бялдрыг хөгжүүлэх, гамшигтай тэмцэх ур чадварыг дээшлүүлэх, гамшгийн аюулаас нэрвэгсдийг аврах, эрэн хайх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг дадлага олгоход чиглэгдэнэ.

Нэг: Оролцох баг, хугацаа:

Хэнтий аймгийн Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудын дунд "Аврагч-2019" бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 6 бүсэд хувааж явуулах ба баг тус бүр 9 тамирчны бүрэлдэхүүнтэй оролцоно. / 1 ахлагч, 4 эрэгтэй, 4 эмэгтэй/

Хойд бүс - Өмнөдэлгэр, Хурх, Батширээт, Биндэр сум, тосгодын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн баг тамирчид хамрагдана. 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Биндэрийн овооны орчим зохион байгуулагдана.

Зүүн хойд бүс- Баян-Адарга, Дадал, Норовлин сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн баг тамирчид хамрагдана. 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Шивэр мандал орчим зохион байгуулагдана.

Зүүн бүс - Батноров, Бэрх, Баян-Овоо сум, тосгодын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн баг тамирчид хамрагдана. 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Баян уул орчим зохион байгуулагдана.

Төвийн бүс- Мөрөн, Өлзийт, Хэрлэн, Тахилгат, Баянхутаг сум, тосгодын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн баг тамирчид хамрагдана. 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Өндөрхаан уулын энгэрт зохион байгуулагдана.

Баруун бүс - Жаргалтхаан, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Хэрлэнбаян -Улаан зэрэг сум, тосгодын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн баг тамирчид хамрагдана. 2019 оны 03 дугаар сарын 28 -ны өдөр Шивэрийн сайр орчим зохион байгуулагдана.

Урд бүс- Дархан, Галшар, Бор-Өндөр, Баянмөнх сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн баг тамирчид хамрагдана. 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 3 сумын уулзвар газарт зохион байгуулагдана.

Хоёр: Тэмцээний төрөл

1.Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн суманд зохион байгуулж буй ажлын илтгэх хуудас

2. Багийн гишүүдийн цэрэгжилч жагсаалч байдал, жагсаалын хувиргалт

3. Асуулт /хууль эрх зүй, дүрмүүдээс -Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль/

7км-ийн марш

- Торон саадыг давах
- Элстэй хайрцаг зөөх /тэсэрч дэлбэрэх бодис зөөх/
- Химийн 1, 2-р норматив
- Тэвшин дэх галыг унтраах, үлээгч аппаратны гэмтэл олж асаах
- Байр зүйн аргаар өгөгдсөн тэмдэгтийг олох
- Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, ФЛО-оор байрлуулсан галыг шүршиж унтраах.

Гурав: Тэмцээнийг дүгнэх журам

Тэмцээний дүнг гаргахдаа 7 км-ийн саадтай гүйлтийн нийт хугацаанаас шагналын минутыг хасаж, торгуулийн оноог нэмж хамгийн бага цагаар байр эзлүүлнэ.

Техникийн зөвлөгөөнийг тэмцээн болох өдрөөс нэг хоногийн өмнө тухайн сумын хурлын танхимд зохион байгуулна.

Жич: Тэмцээний 6 цэг дээр баг бүрээс 1 хөндлөнгийн шүүгч тавьж болно.

Хөндлөнгийн шүүгчид нь тухайн цэг дээр байгаа шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэрт нөлөөлөхгүй, хяналт тавьж ажиллах ба илт буруу шийдвэр гаргавал ерөнхий шүүгчид бичгээр болон камер, фото зургаар танилцуулж, асуудлыг газар дээр нь шийдвэрлүүлнэ.

Маршийн замд багийн гишүүнд дэмжлэг үзүүлэх, машинд суулгах, солих, тамирчин маршийн замаас хасагдах зэрэг зөрчил гаргасан багт 10 минутын торгуулийн оноог нэмнэ.

Тэмцээнд оролцох баг тамирчдыг эмнэлгийн үзлэгээр оруулж "тэнцэнэ" гэсэн бичгийг мэдүүлгийн хамт ирүүлэх.

Дөрөв: Шагнал

1-р байр 1, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байр 1, мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр 1, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

Тав: Бусад

Тэмцээнд оролцох сум, тосгоны баг тамирчдын томилолт, хоол, унааны зардал болон шагналын 200000,0 /хоёр зуун мянган/ төгрөгийг тухайн орон нутаг хариуцна.

Тэмцээнд оролцох баг тус бүр 1ш 5 кг-ын гал унтраагуур авч ирнэ.

Тэмцээний зааврыг 98218996, 98249797 дугаарын утсаар лавлаж болно.

Дүгнэлт:

Тэмцээн зохион байгуулсан талаар илтгэл хуудсыг аймгийн Засаг даргад танилцуулж, цаашид авах арга хэмжээг шийдвэрлүүлнэ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ

